

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

Агуулга.....	1
1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	9
3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	9
3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	10
3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	12
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“ЦАХИМ ЭРҮҮЛ МЭНД” ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ С.ЭНХБОЛД
ТАНАА

2020-02-27 № 06/619
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Цахим эрүүл мэнд” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Цахим эрүүл мэнд” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Цахим эрүүл мэнд” төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус төсөлд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Цахим эрүүл мэнд” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч С.Энхболд Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Цахим эрүүл мэнд” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Цахим эрүүл мэнд” төсөл нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 20-ноос 2020 оны 02 дугаар сарын 27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төслийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Нийслэл аудит” ХХК-ийн аудитор Б.Өлзийзаяа, шинжээч Д.Энхтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Цахим эрүүл мэнд” төслийн удирдлага 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 06 тоот албан бичгээр Үндэсний аудитын газар, “Нийслэл-Аудит” ХХК-д ирүүлсэн.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Цахим эрүүл мэнд” төслийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Эрүүл мэндийн үйлчилгээг илүү сайн хүргэхийн тулд эрүүл мэндийн мэдээллийн нэгдмэл байдал, хэрэглээ

болон Цахим эрүүл мэндийн шийдлүүдийг сайжруулах, Улсын төв 1, 2, 3 дугаар эмнэлэг болон Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд туршилтыг хэрэгжүүлэх” юм.

“Цахим эрүүл мэнд” төслийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цахим эрүүл мэндийн нэгдсэн тогтолцоог байгуулах
- Байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлж, чадавхжуулах
- Төслийн удирдлага

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй бөгөөд хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалын
1 дүгээр хавсралт “Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн болох Засгийн газрын шугамаар авч ашиглаж буй хөнгөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”
2 дугаар хавсралт санхүүгийн тайлан тодруулгын маягтууд,
3 дугаар хавсралт санхүүгийн тайланг бэлтгэх.
- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалын хавсралт “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”
- Дэлхийн банкны худалдан авах ажиллагааны журам
- Дэлхийн банкны төсөл хэрэгжүүлэх заавар
- Дэлхийн банкны төслийн хөрөнгийн зарцуулалтын захидал

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус төслийн Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа Дэлхийн банкнаас гаргасан төсөл хэрэгжүүлэх заавар нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Цахим эрүүл мэнд” төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Infosystems” програм хангамж ашигладаг байна.

“Цахим эрүүл мэнд” төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Цахим эрүүл мэнд” төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 4 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын гүйцэтгэлийн үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн *санхүүгийн үр дүнгийн* тайлангийн *нийт зардлыг* сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн нийт дүн 2,472,323.0 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 49,446.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшингийн суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгосон нь төслийн зээлийг үр ашигтай зарцуулж байгаа эсэхийг шалгах шаардлагатай гэж үзсэнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Цахим эрүүл мэнд” төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 136,970.5 мянган төгрөгөөр буюу 1.06 хувиар буурсан нь тайлант онд төслийн зээлийн зарцуулалт өндөр байсантай холбоотой.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,076,956.6	1,953,656.2	(123,300.4)
Авлага	11,931.2	1,497.1	(10,434.1)
Үндсэн хөрөнгө	157,540.8	155,608.8	(3,235.9)
Нийт хөрөнгө	2,250,340.6	2,113,370.1	(136,970.5)
Өр төлбөр	67.7	272.3	204.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,250,340.6	2,113,370.1	(136,970.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,250,340.6	2,113,370.1	(136,970.5)

Авлага дансны үлдэгдэл 10,434.1 мянган төгрөгөөр буурсан нь шатахууны урьдчилгаа болон дотоод томилолтын урьдчилгаа төлбөрүүдийг төлөгдсөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,235.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардал өссөнөөс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 204.7 мянган төгрөгөөр өссөн нь жилийн эцсийн цалин суутганы тайлангаар тодорхойлсон хувь хүний татварын өглөгийн төлөгдөөгүй үлдэгдэл дүнгээс шалтгаалсан байна .

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,113,370.1 мянган төгрөг болж 136,970.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгаар 13,272.7 мянган төгрөгөөр өмнөх үеийн үр дүн өссөн нь төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн ашиглагдах жилд өөрчлөлт орсонтой холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагаанд зориулан 3,608,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 2,208,864.1 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Нийт зардлын 2,115,687.9 мянган төгрөгийг Олон улсын ассоциацийн хөнгөлөлттэй зээлээр, 39,300.0 мянган төгрөгийг улсын төсвийн санхүүжилтээр, 53,876.2 төгрөгийг бусад туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Тайлант хугацаанд Монгол улсын бүх аймаг сумдын анхан шатны эмнэлгийн байгууллагуудын ажилтнуудад ажлын байран дээр сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн боловч сургалтын хэлбэр өөрчлөгдөж цахимаар явуулснаас дотоод томилолтын зардал 121,673.3 мянган төгрөгөөр, зарим зөвлөхийн тендер 2020 онд шилжсэнээс бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардал 226,118.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэгджээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,372,893.5 мянган төгрөг буюу 86.6 хувьтай байгаа нь дотоод томилолтын зардлын хэмнэлт, зарим зөвлөх шалгаруулах тендер хойшлогдсоноос шалтгаалсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 4 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2019 оны аудитаар үйл ажиллагааны орлого, зарлага, цалингийн зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоолол, ангилал, тайлант худалдан авсан бараа ажил үйлчилгээ, зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт, анхан шатны баримтын хүчин төгөлдөр байдлыг бүрэн шалгасан бөгөөд анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

“Цахим эрүүл мэнд” төсөл Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 88 мэдээллийг хугацаанд нь, 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгөгдсөн бөгөөд зөвлөмжийг бүрэн биелүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Цахим эрүүл мэнд” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

“Цахим эрүүл мэнд” төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг

холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,088,887,805.6	1,955,153,295.9
31	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,076,956,601.0	1,953,656,203.9
31210	Банкнид байгаа бэлэн мөнгө /долларын данс/ Төрийн банк	2,076,956,601.0	1,390,932,599.4
31211	Банкинд байгаа бэлэн мөнгө /Төрийн сан Хөрөнгө оруулалтын данс/		546,262,254.9
31212	Банкинд байгаа бэлэн мөнгө /Төрийн сан Үйл ажиллагааны данс/		16,461,349.7
33	Авлага	11,931,204.6	1,497,092.0
33200	Төлбөртэй үйлжилгээний авлага		
33201	Татаас санхүүжилтийн авлага	10,557,561.0	
33500	Бусад авлага	1,373,643.7	1,497,092.0
34	Урьдчилж төлсөн төлбөр	-	-
34710	Урьдчилгаа тооцоо		
2	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	161,452,782.5	158,216,834.4
39	Үндсэн хөрөнгө	157,540,782.5	155,608,834.4
39201	Барилга байгууламж		
39202	Хуримтлагдсан элэгдэл		
39203	Авто-тээврийн хэрэгсэл	132,727,272.7	132,727,272.7
39204	Хуримтлагдсан элэгдэл	(26,545,454.6)	(26,545,454.6)
39205	Машин, тоног төхөөрөмж	39,590,364.5	47,549,485.5
39206	Хуримтлагдсан элэгдэл	(13,786,432.7)	(22,644,312.5)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,304,753.8	33,791,754.3
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,749,721.2)	(9,269,911.0)
39301	Программ хангамж	6,520,000.0	6,520,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,608,000.0)	(3,912,000.0)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,250,340,588.1	2,113,370,130.4
41	Богино хугацаат өр төлбөр	67,666.7	272,323.8
41300	Өглөг		
41360	Бусад өглөг	67,666.7	272,323.8
	УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН		
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	67,666.7	272,323.8
51100	Засгийн газрын хувь оролцоо	2,250,340,588.1	2,113,370,130.4
51101	Хуримтлагдсан үр дүн	2,250,272,921.5	2,113,097,806.6
51210	Өмнөх үеийн үр дүн	2,109,454,941.7	2,263,613,315.4
51220	Тайлант үеийн үр дүн	140,817,979.8	(150,515,508.8)
51300	Дахин үнэлгээний нэмэгдэл		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,250,272,921.5	2,113,097,806.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,250,340,588.1	2,113,370,130.4

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
120001	Улсын төсвөөс	32,710,600.0	39,300,000.0
120002	НӨТ-ын хөнгөлөлт		82,771,967.3
120003	Зээлийн хөрөнгийн эх үүсвэрээс олгосон санхүүжилтийн орлого	1,252,807,826.5	2,115,687,941.9
	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,088,887,805.6	1,955,153,295.9
120009	Бусад орлого	4,480,195.4	
120002	Хүүгийн орлого	6,013,999.9	37,192,929.6
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,335,958,375.3	2,281,078,517.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,307,288,412.3	2,472,323,032.5
	Бусад бараа үйлчилгээний зардал	1,307,288,412.3	2,472,323,032.5
210401	Бичиг хэргийн материал	7,311,248.0	5,392,267.1
210402	Тээвэр, шатахууны зардал	6,302,436.0	8,180,008.0
210403	Шуудан холбооны зардал	11,982,585.4	12,373,370.5
210404	Дотоод томилолтын зардал	23,188,294.0	4,326,645.0
210405	Ном, хэвлэлийн зардал	5,143,554.0	6,460,372.0
210406	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардал	1,167,735,552.9	2,276,963,323.4
210407	Жижиг эд хогшил худалдан авах зардал /Бараа бүт худ/авах	4,350,245.3	1,746,987.0
210408	Төлбөр, хураамж, жижиг татварууд	5,430,429.5	82,771,967.3
210409	Урсгал засварын зардал	1,775,987.0	4,153,295.4
210410	Бусад зардал	749,259.0	
210411	Байрны түрээсийн зардал	3,270,000.0	3,700,000.0
210412	Элэгдлийн зардал	37,338,221.2	26,954,796.9
210413	Төвлөрүүлэн шилжүүлэг	32,710,600.0	39,300,000.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,307,288,412.3	2,472,323,032.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	28,669,963.0	(191,244,515.4)
14	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз(бодит)	112,148,016.8	40,729,006.6
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)		40,729,006.6
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	140,817,979.8	(150,515,508.8)

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,331,478,179.9	2,208,864,110.8
120001	Улсын төсвөөс	32,710,600.0	39,300,000.0
120004	Зээлийн хөрөнгийн эх үүсвэрээс олгосон санхүүжилтийн орлого	1,252,807,826.5	2,115,687,941.9
120005	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,945,753.6	
120002	Хүүгийн орлого	6,013,999.9	37,192,929.6
120003	Тендерийн орлого		6,125,678.3
120006	Хоорондын тооцоогоор		10,557,561.0
2132	Бараа, үйлчилгээний урсгал зардал	1,292,097,967.8	2,372,893,514.4
210401	Бичиг хэргийн материал	7,311,248.6	5,392,267.1
210402	Тээвэр, шатахууны зардал	8,237,443.0	8,712,943.0
210403	Шуудан холбооны зардал	11,982,585.4	12,373,370.5
210702	Дотоод томилолтын зардал	23,188,294.0	4,326,645.0
210703	Ном, хэвлэлийн зардал	5,143,554.0	6,460,372.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардал	1,167,107,682.0	2,276,281,512.8
210601	Багаж техник хэрэгсэл	14,527,434.1	7,959,121.5
210602	Тавилга	237,000.0	2,487,000.1
210603	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	4,350,245.3	1,746,987.0
210604	Урсгал засвар	1,775,987.0	4,153,295.4
210605	Төлбөр, хураамж, жижиг татварууд	949,074.4	
210805	Тээвэр оношлогоо	22,725.0	
210806	Бусад зардал	726,534.0	
210807	Байрны түрээсийн зардал	3,270,000.0	3,700,000.0
210808	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэн шилжүүлэг	32,710,600.0	39,300,000.0
210809	Төсвийн ерөнхийлөн захирагчийн хоорондын тооцоо	10,557,561.0	
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	1,292,097,967.8	2,372,893,514.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	39,380,212.2	(164,029,403.7)
14	Валютин ханшийн зөрүү	112,148,016.8	40,729,006.6
145001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз(бодит)	112,148,016.8	
145002	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз(бодит)		40,729,006.6
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII)	151,528,228.9	(123,300,397.1)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,925,428,372.1	2,076,956,601.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,076,956,601.0	1,953,656,203.9

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-		2,250,340,588.1	2,250,340,588.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			13,272,727.3	13,272,727.3
Залруулсан үлдэгдэл			2,263,613,315.4	2,263,613,315.4
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			-	
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл			2,263,613,315.4	2,263,613,315.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Залруулсан үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			(150,515,508.8)	(150,515,508.8)
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл			2,113,097,806.6	2,113,097,806.6

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны			Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,076,956,601.0	2,076,956,601.0	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,608,000,000.0	2,372,893,514.4	(1,235,106,485.6)	66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,740,000,000.0	2,372,893,514.4	(367,106,485.6)	87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,740,000,000.0	2,372,893,514.4	(367,106,485.6)	87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,480,000.0	3,700,000.0	(8,780,000.0)	30
210301	Гэрэл, цахилгаан	4,800,000.0		(4,800,000.0)	-
210304	Байрны түрээс	7,680,000.0	3,700,000.0	(3,980,000.0)	48
2104	Хангамж, бараа материалын зардал	64,800,000.0	34,685,939.6	(30,114,060.4)	54
210401	Бичиг хэрэг	11,520,000.0	5,392,267.1	(6,127,732.9)	47
210402	Тээвэр, шатахуун	19,200,000.0	8,712,943.0	(10,487,057.0)	45
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,560,000.0	12,373,370.5	1,813,370.5	117
210404	Ном, хэвлэл	12,000,000.0	6,460,372.0	(5,539,628.0)	54
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,520,000.0	1,746,987.0	(9,773,013.0)	15
2105	Нормативт зардал		-	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,320,000.0	14,599,417.0	(19,720,583.0)	43
210601	Багаж хэрэгсэл	13,920,000.0	7,959,121.5	(5,960,878.5)	57
201602	Тавилга	9,600,000.0	2,487,000.1	(7,112,999.9)	26
210604	Урсгал засвар	10,800,000.0	4,153,295.4	(6,646,704.6)	38
2107	Томилолт, зочны зардал	126,000,000.0	4,326,645.0	(121,673,355.0)	3
210702	Дотоод албан томилолт	126,000,000.0	4,326,645.0	(121,673,355.0)	3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,502,400,000.0	2,276,281,512.8	(226,118,487.2)	91
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,502,400,000.0	2,276,281,512.8	(226,118,487.2)	91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	39,300,000.0	39,300,000.0	-
213208	Төвлөрүүлэн шилжүүлэг		39,300,000.0	39,300,000.0	-
2133	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	868,000,000.0		(868,000,000.0)	-
213304	Хөрөнгийн зардал	868,000,000.0		(868,000,000.0)	-
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,647,300,000.0	2,208,864,110.8	(1,438,435,889.2)	61
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		6,125,678.3	6,125,678.3	-
1200043	урьд оны үлдэгдэлээс санхүүжих		10,557,561.0	10,557,561.0	-
1200044	Улсын төсвөөс	39,300,000.0	39,300,000.0	-	100
1200045	Зээлийн санхүүжилтээс	3,608,000,000.0	2,115,687,941.9	(1,492,312,058.1)	59
1200046	Банкны хүү		37,192,929.6	37,192,929.6	-
145010	Валютын ханшны олз		40,729,006.6	40,729,006.6	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,076,956,601.0	2,076,956,601.0	-	100
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,953,656,203.9	1,953,656,203.9	-

